



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Зорчигч тээврийн хэрэгслийн гарах хөдөлгөөн,  
бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалт,  
үзвэр үйлчилгээ, цахим болон хүүхдийн тоглоомын төвүүдийн  
үйл ажиллагааг түр зогсоох тухай

Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 33 дугаар  
хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлээс гарах хот хоорондын зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгсэл, орон нутгийн хуваарьт нислэг, суудлын галт тэрэгний хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 02:00 цагаас 11 дүгээр сарын 13-ны өдрийн 23:00 цаг хүртэл түр зогсоож холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хурандаа Ж.Болд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, нийслэлийн Онцгой комиссын дарга Д.Сумъяабазар нарт үүрэг болгосугай.

2. Нийслэлийн бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл түр зогсоохыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт даалгасугай.

3. Үзвэр үйлчилгээний байгууллагууд болон олон нийтийг хамарсан хурал цуглаан, сургалт, спортын тэмцээн уралдаан, соёл урлаг, кинотеатр, цахим болон бага насны хүүхдийн төрөл бүрийн тоглоомын газрын үйл ажиллагааг түр зогсоохыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, нийслэлийн Онцгой комиссын дарга Д.Сумъяабазарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,  
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Я.СОДБААТАР

УХА0168